



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/76/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.10 № 21

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА,
ХОШУУЧ Л.ЭРДЭНЭБАТ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110519502



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга, хошууч Л.Эрдэнэбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 29-нээс 2020 оны 02 дугаар сарын 03-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1/106 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
- Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
- Хорих ял эдлүүлэх ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “unicus” программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.



2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 589,700.8 мянган төгрөгөөс тооцон 11,794.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 12,852.3 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,535.8 мянган төгрөгөөр буюу 2,9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	250.8	250.8
Авлага	0.3	-	0.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	104,113.7	97,972.1	-6,141.6
Үндсэн хөрөнгө	1,171,242.5	1,140,597.8	-30,644.7
Нийт хөрөнгө	1,275,356.5	1,238,820.7	36,535.8
Өр төлбөр	-	250.8	250.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,275,356.5	1,238,569.9	-36,786.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,275,356.5	1,238,820.7	36,535.8

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 4,987.9 мянган төгрөгийн хөрөнгийг актлуулах саналаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хүргүүлэн шийдвэрлүүлж данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь хөрөнгө данснаас хассанаас шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 10,152.3 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 399.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, нийт 10,552.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу 30,644.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, акталсан 33,347.1 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөрийн 250.8 мянган төгрөгийн үлдэгдэл нь сэжигтэн хохирогчийн нэрийн дансанд байршуулсан мөнгө байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,238,569.9 мянган төгрөг болж 36,786.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хуримтлагдсан элэгдлийн дүнгээс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тайлант онд 10,780.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 10,785.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100.05 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	10,780.0	10,785.3	5.3	100.05
Нийт дүн	10,780.0	10,785.3	5.3	100.05

Туслах үйл ажиллагааны орлого 5.3 мянган төгрөгөөр давсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 581,581.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 570,801.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 10,780.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 580,791.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Туслах аж ахуйгаас 780,0 мянган төгрөгийн орлогыг авч шатахуунд зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 31 эрсдэл тодорхойлж нийт 31 горим сорил хэрэгжүүллээ.



Аудитаар нийт 5,511.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,909.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Шатахууны зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд газрын дарга албан тушаалын суудлын автомашин хэрэглэн 4592.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.

1.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ны 184 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлэн ажиллана.

2. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн Б/62 дугаар захирамжаар ШШГГ-ын даргад 918.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

2.2. Эрсдэл: Төсвийн сахилга хариуцлага алдагдах.

2.3. Өгсөн зөвлөмж: ЗГ-ын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох" журмын 1.2.1 -д "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг



хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	104113980,76	98222932,90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0,00	250800,00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0,00	250800,00
3121	Төгрөг	0,00	250800,00
31211	Төрийн сангийн харилцах	0,00	250800,00
35	БАРАА МАТЕРИАЛ	104113694,83	97972132,90
351	Түүхий эд материал	9427814,00	7605262,00
35110	Тусгай зориулалттай материал	9427814,00	7605262,00
354	Хангамжийн материал	61095880,83	55396870,90
35410	Бичиг хэргийн материал	122700,00	61800,00
35420	Аж ахуйн материал	45905046,90	45605773,50
35440	Түлш, шатах тослох материал	137100,00	642400,00
35450	Барилгын засварын материал	8205222,93	4807704,40
35460	Хүнсний материал	6725811,00	4279193,00
35600	Мал амьтад	33590000,00	34970000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1171242548,30	1140597779,45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1171242548,30	1140597779,45
392	Биет хөрөнгө	1100582061,20	1070824830,83
39201	Барилга, байгууламж, орон сууц	1070193316,23	1070193316,23
39202	Хуримтлагдсан элэгдэл	-35300005,56	-53623606,20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	117687095,73	84340000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-112244317,88	-83740000,00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	116443863,20	123401053,20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-81192954,14	-95235013,78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33473638,00	37068638,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13136398,38	-16237380,62
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4657824,00	4657824,00
393	Биет бус хөрөнгө	70660487,10	69772948,62
39301	Програм хангамж	6417692,31	6417692,31
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4507205,21	-5394743,69
39303	Бусад биет бус хөрөнгө	68750000,00	68750000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1275356529,06	1238820712,35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0,00	250800,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0,00	250800,00
413	Өглөг	0,00	250800,00
4136	Бусад өглөг	0,00	250800,00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0,00	250800,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1275356529,06	1238569912,35
51	Засгийн газрын хувь оролцоо	1275356529,06	1238569912,35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	191442242,90	191442242,90
51101	Өмч: - төрийн	191442242,90	191442242,90
512	Хуримтлагдсан үр дүн	758088778,91	721302162,20
51210	Өмнөх үеийн үр дүн	758088778,91	758088778,91
51220	Тайлант үеийн үр дүн	0,00	-36786616,71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	325825507,25	325825507,25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1275356529,06	1238820712,35



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	544375688,47	605827592,30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33246088,47	34245992,30
120	Нийтлэг татварын бус орлого	33246088,47	34245992,30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33246088,47	34245992,30
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3114261,76	3320300,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30131826,71	30925692,30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	511129600,00	571581600,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	511129600,00	570801600,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	511129600,00	570801600,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0,00	780000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт	0,00	780000,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	573421747,57	642614209,01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	573421747,57	642614209,01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	565128917,78	635062165,45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	361794314,97	430349311,24
210101	Үндсэн цалин	194333388,57	283979657,28
210102	Нэмэгдэл	143470900,40	125830318,96
210104	Урамшуулал	23990026,00	20539335,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7668903,07	9024962,13
210205	Эрүүл мэндийн даатгал	5964086,13	9024962,13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32484282,00	34292700,00
210301	Гэрэл, цахилгаан	12613429,00	11821799,00
210302	Түлш, халаалт	9512330,00	10074146,00
210303	Цэвэр, бохир ус	10358523,00	12396755,00
2104	Хангамж, бараа материалын зардал	39393548,62	31837316,53
210401	Бичиг хэрэг	3329460,00	3343870,00
210402	Тээвэр, шатахуун	17684100,00	15914700,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5141557,00	2962888,00
210404	Ном, хэвлэл	0,00	162420,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	970000,00	640100,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4404756,00	3825468,00
210408	Бараа материал акталсны зардал	7863675,62	4987870,53
2105	Нормативт зардал	37154415,30	42055523,70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	833410,00	1073219,00
210502	Хоол, хүнс	32296190,00	36872565,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4024815,30	4109739,70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23206088,00	31635003,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0,00	92600,00
210604	Урсгал засвар	23206088,00	31542403,00
2107	Томилолт, зочны зардал	3993200,00	4948600,00
210702	Дотоод албан томилолт	3993200,00	4948600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4661803,00	3799100,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2818200,00	2036000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240000,00	240000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	316703,00	180100,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100000,00	121000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	964900,00	1000000,00
210807	Газрын төлбөр	222000,00	222000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54772362,82	47119648,85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10673415,71	5422690,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	536000,00	500000,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43562947,11	41196958,85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8292829,79	7552043,56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	72000,00	396800,00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	72000,00	396800,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7662981,00	6359653,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7662981,00	6359653,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	557848,79	795590,56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	557848,79	795590,56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-29046059,10	-36786616,71
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-29046059,10	-36786616,71



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	528201401,21	584661309,44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5591500,00	13875300,00
120	Нийтлэг татварын бус орлого	5591500,00	13875300,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5591500,00	13875300,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5591500,00	13875300,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	522609901,21	570786009,44
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	510571751,21	570006009,44
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	510571751,21	570006009,44
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12038150,00	780000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12038150,00	780000,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	528201401,21	584410509,44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	528201401,21	584410509,44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	524336420,21	580934056,44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377589814,97	430349311,24
210101	Үндсэн цалин	194333388,57	283979657,28
210102	Нэмэгдэл	143470900,40	125830318,96
210104	Урамшуулал	23990026,00	20539335,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7666327,24	9024676,20
210205	Эрүүл мэндийн даатгал	5964086,13	9024676,20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32484282,00	34292700,00
210301	Гэрэл, цахилгаан	12613429,00	11821799,00
210302	Түлш, халаалт	9512330,00	10074146,00
210303	Цэвэр, бохир ус	10358523,00	12396755,00
2104	Хангамж, бараа материалын зардал	30100767,00	27593613,00
210401	Бичиг хэрэг	3120720,00	3282970,00
210402	Тээвэр, шатахуун	16383600,00	15780000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5213557,00	2955838,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	970000,00	640100,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4412890,00	4934705,00
2105	Нормативт зардал	35197963,00	35499166,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	833410,00	1073219,00
210502	Хоол, хүнс	34364553,00	34425947,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23738688,00	27800000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1237000,00	1771997,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0,00	92600,00
210604	Урсгал засвар	22501688,00	25935403,00
2107	Томилолт, зочны зардал	3993200,00	4948600,00
210702	Дотоод албан томилолт	3993200,00	4948600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7573478,00	6638300,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5409700,00	4875200,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240000,00	240000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	316703,00	180100,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100000,00	121000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	964900,00	1000000,00
210807	Газрын төлбөр	222000,00	222000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5991900,00	4787690,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5491900,00	4287690,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500000,00	500000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3864981,00	3476453,00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	72000,00	396800,00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	72000,00	396800,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3792981,00	3079653,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3792981,00	3079653,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0,00	250800,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0,00	250800,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0,00	0,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0,00	250800,00



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122 692 242,90	144 560,00	795 618 543,01	918 455 345,91
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	68 750 000,00	0,00	0,00	68 750 000,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191 442 242,90	144 560,00	795 618 543,01	987 205 345,91
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0,00	325 680 947,25	0,00	325 680 947,25
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0,00	0,00	0,00	0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0,00	0,00	0,00	0,00
C07	Тайлант үеийн үр дүн			-37 529 764,10	-37 529 764,10
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191 442 242,90	325 825 507,25	758 088 778,91	1 275 356 529,06
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191 442 242,90	651 506 454,50	720 559 014,81	1 275 356 529,06
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	0,00	0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191 442 242,90	325 825 507,25	758 088 778,91	1 275 356 529,06
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0,00	0,00	0,00	0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0,00
D08	Тайлант үеийн үр дүн			-36 786 616,71	-36 786 616,71
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191 442 242,90	325 825 507,25	721 302 162,20	1 238 569 912,35



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	581581600,00	584410509,44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	581581600,00	584410509,44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	578040800,00	580934056,44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430377000,00	430349311,24
210101	Үндсэн цалин	265944200,00	283979657,28
210102	Нэмэгдэл	159439800,00	125830318,96
210104	Урамшуулал	1000000,00	20539335,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9463600,00	9024676,20
210205	Эрүүл мэндийн даатгал	9463600,00	9024676,20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34300000,00	34292700,00
210301	Гэрэл, цахилгаан	12300000,00	11821799,00
210302	Түлш, халаалт	12000000,00	10074146,00
210303	Цэвэр, бохир ус	10000000,00	12396755,00
2104	Хангамж, бараа материалын зардал	26817000,00	27593613,00
210401	Бичиг хэрэг	2125000,00	3282970,00
210402	Тээвэр, шатахуун	17352000,00	15780000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3250000,00	2955838,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540000,00	640100,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3550000,00	4934705,00
2105	Нормативт зардал	35500000,00	35499166,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1000000,00	1073219,00
210502	Хоол, хүнс	34500000,00	34425947,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27800000,00	27800000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6200000,00	1771997,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200000,00	92600,00
210604	Урсгал засвар	21400000,00	25935403,00
2107	Томилолт, зочны зардал	4949600,00	4948600,00
210702	Дотоод албан томилолт	4949600,00	4948600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4033600,00	6638300,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2036000,00	4875200,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400000,00	240000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245600,00	180100,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	130000,00	121000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100000,00	100000,00
210807	Газрын төлбөр	222000,00	222000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4800000,00	4787690,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4300000,00	4287690,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500000,00	500000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3540800,00	3476453,00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	460800,00	396800,00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	460800,00	396800,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3080000,00	3079653,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3080000,00	3079653,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	581581600,00	585472490,56
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	570801600,00	571597190,56
131001	Улсын төсвөөс санхүүжих	570801600,00	571597190,56
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10780000,00	13875300,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10780000,00	13875300,00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		250800,00

